



ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ  
**БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРООНЫ  
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 02 сарын 06 өдөр

Дугаар А/166

Улаанбаатар хот

Пара хөнгөн атлетикийн Үндэсний шигшээ  
багийн бүрэлдэхүүнийг батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1 дэх заалт, 8.4 дэх хэсэг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.7 дахь заалт, 11 дүгээр зүйлийн 11.3.7, 11.3.9 дэх заалт, 18 дугаар зүйлийн 18.3, 18.4 дэх хэсэг, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг, Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны даргын 2023 оны А/22 дугаар тушаалаар батлагдсан “Үндэсний шигшээ багийг бүрдүүлэх спортын төрлийг сонгох, санхүүжүүлэх журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Пара хөнгөн атлетикийн Үндэсний шигшээ багийн бүрэлдэхүүний нэрсийг хавсралтаар баталсугай.

2.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг ханган тус хуулийн 08 дугаар зүйлд заагдсан нээлттэй мэдээллийг байгууллагын цахим хуудсанд байршуулан мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллахыг Монголын Үндэсний пара хөнгөн атлетикийн холбоонд үүрэг болгосугай.

3.Батлагдсан бүрэлдэхүүн, орон тооны дагуу цалин, нийгмийн даатгалын шимтгэлийг сар бүр Монголын Үндэсний пара хөнгөн атлетикийн холбоонд шилжүүлэхийг Агентлагийн ерөнхий нягтлан бодогч (А.Өнөрцэцэг)-д зөвшөөрсүгэй.

4.Цалин, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан, хувь хүний орлогын албан татварын тайланг улирал тутам хянаж, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллахыг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс (Д.Цэрэнболд)-т, холбооны саналыг үндэслэн бүрэлдэхүүн хөдөлгөөнд тухай бүр өөрчлөлт оруулахыг Үндэсний шигшээ багийн бодлогын хэрэгжилтийн хэлтэс (Э.Билэгт)-т тус тус үүрэг болгосугай.

5.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавин ажиллахыг Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтэс (Н.Батсүх)-т даалгасугай.


ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



О.БАТТУЛГА

143410130

Биеийн тамир, спортын улсын хорооны  
даргын 2024 оны 02 дугаар сарын 06 ны  
өдрийн 166 дугаар тушаалын хавсралт



ПАРА ХӨНГӨН АТЛЕТИКИЙН ҮНДЭСНИЙ ШИГШЭЭ БАГИЙН  
БҮРЭЛДЭХҮҮН

№	Овог	Нэр	Үүрэг
1			Дасгалжуулагч
2			Дасгалжуулагч
3	Чойлонбор	Бат-Отгон	Тамирчин
4	Бямба-Очир	Гармаабазар	Тамирчин
5	Пүрэвцог	Энхманлай	Тамирчин
6	Дагвадорж	Саруултөгс	Тамирчин
7	Цэгмид	Баттулга	Тамирчин
8	Төмөрсүрэн	Мядагмаа	Тамирчин

--oOo--